

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын
Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /2017-02-23/**

Ажлын хэсгийн 43 дугаар хуралдаан 2017 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 10.15 цагт Сангийн яамны 9 давхарын хурлын танхимд зохиогдов.

Ажлын хэсгийн хуралдаанд Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Ажлын хэсгийн ахлагч Н.Энхбаяр, Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын ахлах мэргэжилтэн Б.Саран, Татварын ерөнхий газрын ахлах мэргэжилтэн н.Батцэнгэл, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны мэргэжилтэн н.Эрдэнэбат, Ашигт малтмалын газрын мэргэжилтэн Г.Оюунтуяа, Сангийн яамны НББ-ийн газрын мэргэжилтэн Г.Зулай, Хил хязгааргүй алхам ТББ-ын тэргүүн Н.Баярсайхан, Байгаль эхийн аврал сан ТББ-ын тэргүүн Б.Наранцэцэг, Ил тод сан ТББ-ын гүйцэтгэх захирал Д.Цэрэнжав, Хөвсгөл далайн эзэд ТББ-ын тэргүүн Б.Баярмаа, Хариуцлагатай уул уурхайн санаачилга ТББ-ын гүйцэтгэх захирал Батсайхан, МБОИЗ-ийн Удирдах зөвлөлийн гишүүн Б.Батболд, Бороо гоулд ХХК-ийн ахлах нягтлан бодогч П.Болормаа, Арева монгол ХХК-ны ажилтан Анжилай, Петроматад ХХК-ийн гүйцэтгэх захирлыг орлож нягтлан бодогч н.Солонго, Оюутолгой ХХК-ийн мэргэжилтэн н.Амар, Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нар оролцов. Хуралд ажлын хэсгийн 33 гишүүнээс 17 гишүүн оролцож ирц 54,5 хувьтай байв.

Мөн хуралдаанд ажлын албаны харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа, санхүүгийн ажилтан А.Отгонтунгалаг болон Мэдээлэлийн технологийн зөвлөх Г.Ганбат, Адам Смит байгууллагын хөтөлбөрийн зохицуулагч Золжаргал нар оролцов.

Хуралдааныг Ерөнхий сайдын ахлах зөвлөх Н.Энхбаяр нээж, хурлын хэлэлцэх асуудал болон дотоод журмыг танилцуулснаар хурал эхлэв.

Н.Энхбаяр: Та бүхэнд энэ өдрийн амгаланг аймтгая. 2017 оны ажлын хэсгийн эхний хуралдааныг хийж байна, хуралдаандаа хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа. Өнөөдрийн хуралдаанаар хоёр асуудлыг хэлэлцэхээр төлөвлөж байна. Үүнд, Европын сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилттэй орон нутгийн харилцааны туршилтын төслийн хүрээнд жишиг 5 сум сонгох шалгууруудын талаарх танилцуулгыг сонсож хэлэлцэн шийднэ, хоёрдугаар асуудал Монголын ОУИТБС-ын Баталгаажуулалтын дүнгийн талаарх ОУ-ын Удирдах хорооноос ирүүлсэн шийдвэрийг танилцуулна. Ингээд эхний танилцуулгаа сонсоё.

I. ХЭЛЭЛЦСЭН нь: Европын сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилттэй орон нутгийн харилцааны туршилтын төслийн хүрээнд жишиг 5 сум сонгох шалгууруудын танилцуулга

Б.Золжаргал: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе, энэ төслийн зохицуулагчаар ажиллаж байна, өмнө нь Австралийн төсөл дээр ажиллаж байсан, бизнесийн ухааны бакалавр зэрэгтэй, Австралид эдийн засгийн магистр хамгаалсан.

Энэ төслийг Европын сэргээн босголт хөгжлийн банк санхүүжүүлж, Адам Смит байгууллага хэрэгжүүлж байна, туршилтын төсөл байгаа, энэ нь хэрвээ амжилттай хэрэгжвэл дараа дараагийн сумдад хэрэгжүүлэх зорилготой. Төслийн

зорилго нь ОУИТБС-ыг орон нутагт суртчилах, орон нутгийн иргэдийг мэдээллээр хангах юм. Төслийн гол ажлыг харилцаа холбооны байгууллага хариуцан ажиллана, энэ компанийг сонгон шалгаруулах ажил явагдаж байна, үүнд 9 байгууллага саналаа ирүүлсэн, 3 дугаар сарын эхээр шалгаруулна. Туршилтын 5 сумыг сонгож хөтөлбөрөө хэрэгжүүлнэ. Эдгээр сумдыг сонгохын тулд арга зүй боловсруулж, шалгуур үзүүлэлтийг гаргасан. Шалгуур үзүүлэлтийг гаргахад Адам Смит байгууллагын төслийг хариуцсан менежер ажлын албан дээр 14 хоног ажиллаж, ажлын албатай хамтран боловсруулсан. Шалгуур үзүүлэлтүүдийг үндсэн болон нэмэлт гэж ангилаад 331 сумдаас шүүж хасах замаар сумдыг сонгосон. 331 сумаас зөвхөн 5 сумыг сонгон төслөө хэрэгжүүлнэ. Шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулахдаа орлогын хэмжээ болон цар хүрээ, байгаль орчны хүчин зүйлс, хувийн хэвшлийн оролцоо, нийгмийн хүчин зүйлс, хүн ам болон жендер, дэд бүтэц, донор байгууллага байршил зэргийг харгалзан боловсруулсан. Үндсэн шалгуур үзүүлэлтэд цар хүрээ, компаниудын зүгээс дэмжлэг үзүүлэх хүсэл эрмэлзлэл, компаниудын тоо, байгаль орчин, нийгэм нэмэлт шалгуурт байршил, бүтээгдхүүний төрөл, хүн амын тоо, ИНБ-ууд болон донор байгууллагуудын үйл ажиллагаа, ТӨХ-иуд, жендер зэрэг асуудлуудыг тусгасан. Зорилтод сумдыг сонгохдоо шүүлтүүрийн аргыг хэрэглэсэн бөгөөд үүний үр дүнд Өмнөговь аймгийн Гурван тэс, Сэлэнгэ аймгийн Ерөө, Төв аймгийн Заамар, Хэнтий аймгийн Дархан болон Дорноговь аймгийн Дэлгэрэх гэсэн 5 сумыг сонгосон. Бид эдгээр сумдад 3 дугаар сарын дундуур ажлын албаны болон ажлын хэсгийн зарим төлөөлөлтэй хамтран очиж ажиллан, тухайн төслийн хэрэгцээ шаардлагыг үнэлээд, тухайн сумын стратеги боловсруулж ажиллана. Үүнд, оролцогч талуудаас нэг нэг хүний төлөөллийг оролцуулан ажиллах байх. /Танилцуулгыг хавсаргав/

Н.Энхбаяр: За баярлалаа. Борлуулалтын орлогыг цаашдаа төгрөгөөр илэрхийлмээр байна. Хүснэгтээс харахад заримыг нь еврогоор харуулсан байна. Одоогийн ханшаар тооцвол 1,3 тэрбум төгрөгний орлого байхаар харагдаж байна. Мөн борлуулалтын орлогыг яг ямар салбарын орлого вэ гэдгийг харуулах хэрэгтэй. Зөвхөн уул уурхайн салбарын орлого уу, эсвэл бүхий л үйл ажиллагааны орлого уу, гэдгийг салгаж харуулах саналтай байна.

Н.Баярсайхан: Сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлтээ хэрхэн боловсруулсан бэ? Шалгуур үзүүлэлтүүд хэр оновчтой байсан бэ, ажлын хэсгийн гишүүдээс санал авсан уу? Зарим шалгуур үзүүлэлт дутагдалтай байгаа нь харагдаж байна. Жендерийн мэдээлэл олдоогүй гэж байна, энэ талаарх мэдээлэл хамгийн элбэг байгаа. Хэрвээ шалгуур үзүүлэлт ашиглаж байгаа юм бол Даланжаргалан сум нилээд ач холбогдолтой байгаа, гэтэл хайгуулын лицензтэй, борлуулалтын орлого олохгүй, нөхөн сэргээлт хийгдэхгүй байгаа зэрэг олон үзүүлэлтээр муу байгаа Дэлгэрэх сумыг яагаад сонгосон бэ? Даланжаргаланг оруулах саналтай байна.

Б.Батболд: Зарим мэдээлэл, судалгаа олдохгүй байна гэж байна, ажилгүйдлийн судалгаа сум болгон дээр баг багаараа байдаг.

н.Батсайхан: Баруун аймгаас ерөөсөө ороогүй байна. Баруун аймаг нилээд онцлогтой, байгаль орчин, тогтоцын талаасаа ч онцлогтой байдаг, тухайлбал, Говь-Алтай аймгийн Цээл сум гэх мэт.

Н.Энхбаяр: За одоо асуултанд хариулах байх. Би хуралдаантай болсон учраас явах боллоо. Хуралдааныг цаашид БОНХЯ-ны ахлах мэргэжилтэн

Б.Саранг удирдан явуулна уу гэж урьж байна. Хуралдаанаа үргэлжлүүлэхийг хүсье.

Н.Золжаргал: Борлуулалтын орлогыг еврогоор илэрхийлсэн байна гэсэн. Энэ нь ЕСБХБ-наас санхүүжиж байгаа учраас еврогоор илэрхийлсэн гэхдээ өмнөх баганад нь төгрөгөөр илэрхийлсэн байгаа. Бид шалгуур үзүүлэлтүүдээ харьцуулж болох тоон мэдээллээр гаргахыг хичээсэн. Жендер болон ажилгүйдэлтэй холбоотой тоон мэдээлэл зөвхөн аймгийн хэмжээний мэдээлэл байсан. Жендерийн талаарх мэдээлэл олдоогүй учраас бид шалгуур үзүүлэлтээ харгалзаж үзээгүй байгаа. Даланжаргалан сумын хувьд Хэнтий аймгийн Бор-Өндөртэй ойролцоо учраас нийлүүлээд хийх боломжтой гэж үзсэн. Баруун аймгуудаас оролцуулах гэсэн боловч баруун аймгаас зөвхөн Говь-Алтай аймгийн Цээл сум орж ирсэн ба тэнд ганцхан Алтайн хүдэр компани үйл ажиллагаа явуулдаг учраас сонголтод оруулаагүй.

Б.Наранцэцэг: Туршилтын сум сонгох талаар санал авахад Увс аймгийн Бөхмөрөн сумыг оруулах санал өгсөн яагаад ороогүй байгаа юм бол?

Б.Золжаргал: Бид аль болох хүн бүрийн саналыг тусгахыг хичээсэн гэхдээ хүн бүр өөр өөрийн сумыг оруулах санал гарсан учраас шалгуур үзүүлэлтэд үндэслэн сонгосон.

Б.Саран: Эхний асуудлын талаар санал, асуулт байхгүй бол шийдвэрийн төслийг уншиж танилцуулъя.

Б.Дэлгэрмаа: Бид сумын төслийг өөр өөр суманд хэрэгжүүлэхээр ямар үр дүн авч ирэх нь вэ гэдгийг харах зорилготой. Ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг сумдыг сонгохоор, үр дүн нь адилхан байна, тухайлбал алтны үйл ажиллагаа явуулдаг сум. Дэлгэрэх сумыг сонгосон шалтгаан нь тэр суманд иргэд болон компанийн хооронд томоохон зөрчил үүссэн юм байна. Иймд ОУИТБС байснаар ямар ач холбогдолтой болохыг харуулах юм. Баруун аймгаас сум сонгогдоогүй байгаа нь борлуулалтын орлогоороо дээгүүрт ороогүй эсвэл зөвхөн ганц компани тухайн суманд үйл ажиллагаа явуулдаг бол сонгогдох боломжгүй байсан байх. Дархан суманд төрийн өмчийн компани ажиллаж байгаа учраас сонгосон. Даланжаргаланг Дэлгэрэх сум явах замд учраас хамтран хэрэгжүүлэх боломжтой гэж үзсэн.

Н.Баярсайхан: Тэгвэл Дэлгэрэх, Даланжаргалан гэсэн 2 сумын нэрээ оруулчихвал болох юм байна гэж ойлголоо.

Б.Золжаргал: Манайх зөвхөн 5 сумыг сонгож үйл ажиллагаа явуулна, Даланжаргаланг ойрхон учраас ойролцоо сумдын үйл ажиллагаанд оролцуулж болно гэж үзсэн. Даланжаргаланд үйл ажиллагаа явуулахгүй.

Б.Батболд: Ойрхон болохоор дайраад гарч болно гэж байна, тэнд ажиллана биз дээ. Тэгээд төсөвт тусгагдаагүй, зардал мөнгө хэтэрсэн гээд төслийн үйл ажиллагаанд муугаар нөлөөлөх юм биш биз?

Б.Золжаргал: Дэлгэрэх суманд л төсөл хэрэгжинэ, Даланжаргалан сумаас ирж оролцож болно.

Б.Батболд: Тэнд хүмүүс ирж оролцоход томилолт, хоол ундны зардал гээд гарна түүнийг яах вэ?

Н.Баярсайхан: Танай АСИ-ийн гадаад зөвлөх яг юу гэсэн бэ, шалгуур үзүүлэлтээрээ Даланжаргалан гараад байдаг, санал Дэлгэрэх дээр байгаа юм байна.

Б.Золжаргал: Бид зөвхөн 5 сумыг шалгуур үзүүлэлтийн дагуу сонгосон, тэнд л төсөл хэрэгжинэ. Зургаан сум сонгох боломжгүй.

П.Болормаа: Эдгээр сумдыг сонгохдоо тоон болон чанарын үзүүлэлтийг авч үзсэн байна. Одоо тоон үзүүлэлт дээр цагаа барах хэрэггүй байх. Дэлгэрэх сум чанарын үзүүлэлтээрээ гараад ирсэн байна. Одоо сонгогдсон байгаа сумдыг дэмжих нь зөв гэсэн саналтай байна.

н.Батсайхан: Ер нь 5 сум гэсэн бол 5-ыг л сонгох ёстой. Шалгуур үзүүлэлт гаргаад өндөр үзүүлэлттэй сумыг сонгох биш янз бүрийн сумыг оруулсан бол зүгээр байна. Баруун аймгийг бага үзүүлэлттэй, цөөхөн компанитай гэж байна. Уг нь олон, цөөн компани үйл ажиллагаа явуулдаг сумдыг аль альныг нь оруулж, харьцуулж үзэхэд өөр өөр үр дүн гарна, болохгүй зүйл байхгүй болов уу.

Б.Саран: Дэлгэрэх сумыг хасаад Даланжаргаланг оруулж болох уу, гэхдээ Даланжаргалан дээр олон төсөл хөтөлбөр хэрэгжиж байгаа. Ямар нэгэн төсөл хэрэгжээгүй, олборлолт хайгуулын ажил эрчимжээгүй суманд амьдарч байгаа иргэдийн санал, бодол ямар байгааг илэрхийлэх талаасаа энэ сумыг сонгосон байх, би энэ төслийн сонголтыг дэмжиж байна, үүнийг батлах саналтай байна.

Н.Баярсайхан: Дээрх 5 сумыг сонгосон байна Гэхдээ гаргасан шалгуур үзүүлэлтээр өндөр оноос авсан Даланжаргалан сумыг хамруулж, ажиллах гэсэн саналыг шийдвэрт оруулах саналтай байна. Сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлт яах гэж гаргасан юм, тэр үзүүлэлтээ л барих хэрэгтэй.

Б.Саран: За шийдвэрийн төсөлд санал хураая.

н.Батцэнгэл: Угаасаа 5 суманд хэрэгжүүлнэ гээд төсөв мөнгөө цэгцэлчихсэн байгаа байх. Энэ сонгосон сумдаа батлах саналтай байна.

Гишүүд шийдвэрийн төслийг дэмжиж батлав.

ХЭЛЭЛЦСЭН нь: Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2015 оны тайлан, 2016 оны Баталгаажуулалтын дүнгийн талаар ОУ-ын Удирдах хорооноос ирүүлсэн шийдвэрийн танилцуулга.

Ш.Цолмон: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. ОУИТБС-ын баталгаажуулалтын ОУ-ын Удирдах хорооноос ирсэн шийдвэрийг танилцуулж байна. Өмнө нь цахим хэлбэрээр байнга танилцуулагдаж байсан. Баталгаажуулалтын тайлан албан ёсоор 2017 оны 1 сард гарсан. 51 оронд ОУИТБС хэрэгжиж байгаагаас 5 орон баталгаажуулалтад хамрагдсан. Эдгээр 5 орон ахицтай ажиллаж байна гэсэн, стандартын дагуу ОУИТБС-ыг хэрэгжүүлж байгаа бөгөөд 100 хувь хангалттай оноо авсан улс байхгүй байна. Манай ОУИТБС-ын талаар нааштай мэдээлэл гарсан, тухайлбал Монголын ОУИТБС-ын оролцогч

талуудын ажлын хэсэг нь үр дүнтэй хяналт явуулсан байна. Цахим сүлжээг ашиглан өгөгдөл мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд сайн ажилласан байна. Орон нутагт дэд зөвлөлүүдийг зохион байгуулж, олон нийтийн хэлэлцүүлгийг, онцгойлон орон нутгийн түвшинд сайн зохион байгуулж, үр өгөөжтэй байж чаджээ. ОУИТБС нь уул уурхайн салбарын удирдлагын талаар зөвөлгөөн, хэлэлцүүлгийн эерэг индэр байж, түүндээ оролцогч талууд болон олон нийтийг хамруулсан байна гэдгийг Удирдах хороо онцолсон байна.

ОУИТБС-ын шаардлага бүрийг Монгол улс хир хангасныг Удирдах хороо тайландаа тодорхой харуулсан байгаа. Монгол улс 1.4, 2.2, 2.3, 2.6, 4.5, 4.9, 5.2, 6.1, 6.2, 7.4 гэсэн шаардлагуудыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна. Ийм учраас бид дутуугаа засч залруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь зүйтэй байна. Нэмэлт засч сайжруулах ажлын үр дүнг 2018 оны 1 дүээр сарын 11-нээс эхлүүлэх дахин баталгаажуулалтаар хянаж үнэлэх юм. Үүнийг цаашид авч хэрэгжүүлэх ёстой гэж /Танилцуулгыг хавсаргав/

ОУИТБС-ын 2015 оны нэгтгэл тайланд ОУНБДнГазраас шүүмж ирсэн байгаа. Үүнд, Өгөгдлийн мэдээллийн чанар буюу шаардлагын 4.9 –ыг хангалтгүй өөрөөр хэлбэл ихэнх Засгийн газрын байгууллагууд болон компаниуд ямар нэгэн мэдээ мэдээлэл гаргаагүй байна гэсэн. Хараат бус хянагч нэгтгэгчтэй хамтран энэ шаардлагыг хэрхэн хангах ажлын хэсгээс зөвлөгөө хийе гэсэн санал байгаа, материаллаг бус байдал шаардлага 4.1-ын 2015 оны тайлан бүх орлогын 99 хувийг хамарч байгаа ч орлогын зүйлүүдийг сонгоход хараат бус нэгтгэгч оролцоогүй байна гэсэн. Бид тайлан гаргах журмаараа явж байгаа, иймээс үүний оролцоог яаж хангах вэ гэдэг асуудал байна. Зарим орлогын урсгалыг тайлбарлаагүй байна. Үүнийг 2016 оны хараат бус нэгтгэгчийн ажлын даалгаварт тусгаж, тайлан гаргаагүй компанийн тайлбар холбогдох дүгнэлтийг тайландаа оруулах шаардлагатай байна. 2015 оны тайлангийн цар хүрээ нь аймаг сум зэрэг нутгийн удирдлагын байгууллагууд орж, орон нутгийн шууд орлогыг харуулсан байгаа ч материаллаг байдалд үнэлгээ дүгнэлт хийсэн зүйл алга байна гэсэн. Манайх цахим тайлангаа ашиглаад материаллаг байдлыг тогтоох ажлыг хийх боломжтой. 2016 оны тайлан гаргахад анхаарах зүйлүүдийг дурдахад, Монгол атомын хөрөнгийг Монгол Чех компани руу шилжүүлсэн гэсэн боловч ямар хэмжээний юм шилжүүлсэн нь тодорхойгүй байна, үүнийг тодорхой болгож тайланд тусгах, түүнчлэн тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, өргөдлийн огноо байхгүй байна гэх мэт дүгнэлт өгсөн. Эдгээр асуудлыг хүлээн зөвшөөрч 2017 оны ажлын төлөвлөгөөнд оруулсан. /Танилцуулгыг хавсаргав/

Б.Саран: За баярлалаа, танилцуулгатай холбогдуулан асуулт байвал асууж болно.

Б.Баярмаа: Ажлын хэсгийн дүрэм журамд өөрчлөлт оруулахад болно гэж дүгнэж байгаа юм байна. Хууль маань 2 дахь хэлэлцүүлэг хийгдэж байна. Зарим асуудлуудыг хуульд суулгаад батлуулчихвал шийдэгдчихмээр харагдаад байгаа. Хуулийн ажлын хэсгийн гишүүдтэй уулзаж байхад саналаа бичээд өгчих, боломж байна гэж байсан. Иргэний нийгмийн зүгээс хэлэлцүүлэгт оролцоод, саналаа гаргаад байгаа. Төр болон компанийнхан бас саналаа өгөөд оролцож болох байх. Зөвхөн ажлын хэсгийн дүрэм журам өөрчлөгдөөд шийдэгдчих асуудал гэж харахгүй байна. Энэ талаар ажиллах уу?

Ш.Цолмон: Өмнө нь Ерөнхий сайдаар нэмэлт ажлын төлөвлөгөө батлуулж ажиллаж байсан. Энэ удаа Ерөнхий сайдаар батлуулах зохимжгүй гэж үзсэн учраас ажлын хэсгийн санал боловсруулах шаардлагатай байна. Хуулийн төслийн талаар сайн мэдэхгүй байна, урьд нь 2 удаа ороод батлагдаагүй. Ажлын дэд хэсгийн хувьд ашиг хүртэгч эздийг ил тод болгох ажлын хүрээнд дэд хэсэг байгуулах ёстой, хуулийн ажлын дэд хэсэг байгуулах саналтай байна. Хуулийн төсөлд их найдах боломжгүй байх. Намрын чуулганаар хэлэлцэх болов уу.

Д.Цэрэнжав: Бүтээгдхүүн хуваах гэрээг ил тод болгох ажлын 2 дугаар улиралд багтаан ил тод болгох гэсэн даалгавар ирсэн байна. Энэ яг юуг ил тод болгоно гэсэн үг вэ? Бүх гэрээг ил тод болгоно гэсэн үг үү, зөвхөн 2015 оны тайлантай холбоотой зүйлийг ил болгох уу?

Ш.Цолмон: Бүх гэрээг шинэ маяганд оруулна, гэрээний зарим нэг хязгаарлалттай тоонуудыг оруулахгүй бусдыг бүгдийг ил болгоно. Тухайн бүтээгдхүүн хуваах гэрээ нь сонгон шалгаруулалтад нөлөөлдөг гэсэн дүгнэлт Уул уурхайн яаманд байдаг.

Н.Баярсайхан: 2018 онд бид дахин баталгаажуулалтад орох юм байна. Бид энэ арга хэмжээнүүд зөвлөмжийг хэрэгжүүлэхэд зөвхөн ажлын хэсгийн журамд өөрчлөлт оруулснаар арга хэмжээ авч болохгүй байх. Маягтуудаа өөрчлөх шаардлага байна, Засгийн газрын 222-р тогтоолдоо өөрчлөлт оруулах замаар Засгийн газарт хэн тайлагнах вэ, ялангуяа төрийн өмчид компанийн ямар мэдээллийг ил болгох зэрэг асуудлууд байгаа учраас тогтоолд өөрчлөлт оруулах нь зүйтэй болов уу. Хараат бус хянагч нэгтгэгчийн ажлын даалгаварт зарим асуудлаа оруулаад ажиллах боломжтой. Зөвлөмжүүдийг ангилж, эрэмбэлээд онлайн хэлбэрээр санал аваад, дэд ажлын хэсэг байгуулж ажиллавал илүү ач холбогдолтой гэж харж байна. Ажлын алба урьдах ажлын хэсгийн хурал дээр ямар шийдвэр гарсан түүнд ямар арга хэмжээ авсан, мөн цаг үеийн ажлын талаар товч мэдээллийг 10-15 минутад багтаагаад хуралдааны өмнө танилцуулж байх санал гаргасан, үүнийгээ ажлын алба хэрэгжүүлээд явбал зүгээр байна.

Б.Саран: За баярлалаа, бид танилцуулгын шийдвэрийн хүрээнд дахин баталгаажуулалтад бэлтгэх дэд ажлын хэсэг байгуулах санал байгаа. Бид хууль батлагдахыг хүлээгээд суугаад байх боломжгүй. Хууль гаргах хугацаа бараг 2 жил байгаа, иймээс ажлын хэсгийн гишүүд дэд ажлын хэсэгт оруулах саналаа өгөөд явах нь зүйтэй байх. Төслийнхөө гол зорилтыг хангах процесс руугаа зүтгэж байсан нь дээр байх гэж бодож байна.

Д.Цэрэнжав: Дэд ажлын хэсэг зөвхөн дахин баталгаажуулалтын чиглэлээр ажиллах уу?

Ш.Цолмон: Дэд ажлын хэсэг нь 2015 оны тайлангийн дүгнэлтээр ямар арга хэмжээ авсан, 2016 оны баталгаажуулалтын даалгаврыг биелүүлэхэд чиглэж ажиллана. Нэг хэсгийг нь тогтоолд өөрчлөлт оруулах замаар, нэг хэсгийг нь хараат бус хянагч нэгтгэгчийн ажлын даалгаварт тусгах гэх мэтээр шийдвэрлэж ажиллах боломжтой, харин дэд ажлын хэсгийн ахлагчаар хэнийг ажиллуулах санал байна, саналаа өгөхийг хүсье. 2017 оны 3 дугаар сарын 6-ны дотор ажлын хэсгээ байгуулах саналтай байгаа.

Д.Цэрэнжав: 2018 он хүртэл урт хугацаатай сонсогдож байна. Энэ ажлын хэсэг нь олон асуудал хамарсан, их том ажлын хэсэг болох юм байна. 2018 оны баталгаажуулалт болоход бас ажлын хэсэг байгуулах болж магадгүй.

Н.Баярсайхан: Баталгаажуулалтын хорооноос өгсөн 13 төрлийн зөвлөмжийг хангаж байж 2018 оны баталгаажуулалтад орох юм байна. Тиймээс баталгаажуулалтын зөвлөмжийг хэрэгжүүлэх нэг дэд ажлын хэсэг, 2015 оны тайлангийн зөвлөмжийг хэрэгжүүлэх буюу жил бүрийн нэгтгэл тайлангаас өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын дэд хэсэг гэж 2 дэд ажлын хэсэг байгуулвал шийдвэр хангагдахаар харагдаж байна.

Б.Баярмаа: 2017 оны ажлын төлөвлөгөөнд журамд өөрчлөлт оруулах асуудал тусгагдсан байгаа. Үүнийг ажлын хэсгийн хурлаараа хэлэлцүүлээд ажлаа зохицуулах арга байна. Асуудлуудаа ялгаж салгах хэрэгтэй. Хууль хэзээ ч батлагдахгүй гэж хаяж болохгүй. Энэ салбарын харилцааг зохицуулах хамгийн чухал хууль яригдаж байхад тэр мөд батлагдахгүй гэж ярих нь буруу. Иргэний нийгмийнхэн саналаа өгөөд, 2 дахь хэлэлцүүлэг явж байхад ийм юм ярьж байгаад би харамсаж байгаа. Хуулин дээрээ анхаараачээ, ийм хайхрамжгүй юм яриад байж болохгүй. Үүнийг анхаарч ажлын төлөвлөгөөнд оруулах саналыг дахин хэлье.

Н.Баярсайхан: Хоёр ажлын хэсэг байгуулж болох уу, заавал нэг байх уу?

Ш.Цолмон: Болно оо, хуулийн гэх мэт тусдаа байх боломжтой, харин хүн хүч хүрэлцэхгүй байх гэж бодож байна.

Б.Баярмаа: Заримыг нь ажлын албанд өгөөд хийж болох байх, зохион байгуулалтын ажил байна.

Н.Баярсайхан: Ажлын алба их ачаалал авбал ажлаа барахгүй, ажил удааширах байх, иймд дэд ажлын хэсэг байгуулсан нь дээр байх.

Б.Саран: Би дэд ажлын хэсэг байх нь зөв гэж үзэж байна. Дэд ажлын хэсгээ олон юмыг хамруулах биш, чиглүүлсэн байвал зүгээр, яг юу хийх вэ гэдгээ томъёолж өгөх хэрэгтэй.

Д.Цэрэнжав: Дахин баталгаажуулалтад бэлтгэх гэхээр зөвхөн нэг арга хэмжээнд зориулсан юм шиг болоод байна, иймд нэрийг нь жаахан өөрчлөх шаардлагатай.

Б.Саран: Мэдээллээс тодорхой болдог асуудлууд байна. Энэ шаардаж байгаа зүйл нь манай хууль дүрэмтэй нийцэх, нийцэхгүй зүйл байна, иймээс хууль дүрэм мэддэг хүмүүс орж ажиллавал зүгээр байх.

Б.Батболд: Баталгаажуулалтын дүгнэлтээр юу хийх ёстойг нь заагаад өгсөн байна. Иймээс үүний дагуу хийх ажлаа дэд ажлын хэсэг хийгээд, бусад тайлангийн зөвлөмжтэй холбоотой асуудлуудаа бид хийгээд явах боломжтой.

Б.Саран: Энэ ил тод болгох асуудлуудыг харахад манай хуулиар ил тод болгож болохгүй юмнууд орсон байна.

Б.Батболд: Дэд ажлын хэсэг нь алиныг ил тод болгох боломжтой боломжгүйг ялгаад, хуулинд оруулах талаар санал гаргаад өгч болно.

Н.Баярсайхан: Хоёр дэд ажлын хэсэг байгуулах нь зүйтэй. Баталгаажуулалтын хорооноос хугацаатай өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх дэд

ажлын хэсэг, жил бүрийн тайлангийн зөвлөмжийн хрэгжилтийг хангах талаар тогтмол хяналт тавьж санууж байдаг нэг дэд ажлын хэсэг гэсэн хоёр ажлын хэсэг байх хэрэгтэй.

Б.Саран: Тэгэхээр хэдэн ажлын хэсэг байгуулах саналтай байна?

Б.Баярмаа: Нэг ажлын хэсэг байсан нь дээр.

Д.Цэрэнжав: Зөвлөмжийг хэрэгжүүлэх ба дахин баталгаажуулалтад бэлтгэх дэд ажлын хэсэг гээд шийдчихье.

Б.Саран: Зөвлөмжийг хэрэгжүүлэх, нөхцөл боломжийг судлах ба дахин баталгаажуулалтад бэлтгэх дэд ажлын хэсэг гэвэл зүгээр. Ажлын хэсэг маань нэр нь зөв байх ёстой, хийх ажил нь тодорхой байж үр дүн гарна.

Б.Батболд: Жил бүрийн тайлангийн зөвлөмжийг хараад ажлын алба төлөвлөгөөндөө тусгаад явж байгаа. Гэтэл дахин үүнийг хийх ажлын хэсэг гарах хэрэгтэй юу?

Ш.Цолмон: Ажлын төлөвлөгөөнд тусгаад явж байгаа, зөвхөн хяналт тавих хэрэгтэй байгаа.

Н.Баярсайхан: Тухайлбал, жил бүрийн тайланд нэгтгэл тайланг Улсын их хурал болон Төсвийн байнгын хороонд танилцуулна гэсэн зөвлөмж гардаг ч үүнийг хэрэгжүүлэхгүй байгаа. Иймээс шийдвэрийг сануулж байх дэд ажлын хэсэг байх хэрэгтэй байгаа.

Б.Саран: Дэд ажлын хэсгийн нэр нь тодорхой байх ёстой. Зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх шийдвэрийн төсөл боловсруулах ба дахин баталгаажуулалтад бэлтгэх дэд ажлын хэсэг байгуулах гэж шийдвэрт оруулахаар боллоо. Дэд ажлын хэсэгт оруулах хүний саналыг аваад, хийх ажлаа тодорхой болгоод холбогдох байгууллагуудад хүргүүлж ажиллах нь зүйтэй. Ингээд шийдвэрийн төслөө батлая.

Гишүүд 100 хувь дэмжсэнээр батлав.

Хуралдаан 11,50 цагт өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

Ерөнхий сайдын ахлах зөвлөх,
ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн
нарийн бичгийн дарга, ажлын хэсгийн
ахлагч



Н.Энхбаяр

БОАЖЯ-ны ахлах мэргэжилтэн

Б.Саран

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга



Ш.Цолмон

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны санхүүгийн ажилтан



А.Отгонтунгалаг

Монголын “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-ын
Ажлын хэсгийн 43 дугаар хуралдааны шийдвэр

Ажлын хэсгийн 43 дугаар хуралдаан 2017 оны 2 дугаар сарын 23-ны өдөр (Пүрэв гараг)-ийн 10,00 – 11,30 цагийн хооронд Сангийн яамны 9 дүгээр давхрын хурлын танхимд болов.

Хуралдааныг Монгол Улсын Ерөнхий сайдын ахлах зөвлөх, ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ажлын хэсгийн ахлагч Н.Энхбаяр удирдав.

Хэлэлцсэн асуудал:

1. Европын Сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилттэй орон нутгийн харилцааны туршилтын төслийн хүрээнд жишиг 5 сум сонгох шалгууруудын танилцуулга- Төсөл хэрэгжүүлэгч- Адам Смит байгууллагын зохицуулагч Н.Золжаргал танилцуулав:

а. Шийдвэр: Төсөл хэрэгжүүлэгч Адам Смит байгууллагаас санал болгосон дараах 5 сум: Төв аймгийн Заамар, Өмнөговь аймгийн Гурвантэс, Сэлэнгэ аймгийн Ерөө, Хэнтий аймгийн Дархан, Дорноговь аймгийн Дэлгэрэх сумдыг дэмжихээр тогтов.

і. Дурдсан 5 сумтай хил залгаа сумдын, ялангуяа АСИ-ийн төслийн багийн шалгуур үзүүлэлтийг танилцуулсанаар өндөр оноо авсан Дорноговь аймгийн Даланжаргалан сумын ОУИТБС-ын дэд зөвлөлийг туршилтын төсөлд оролцуулж, зохион байгуулах арга хэмжээнд хамруулахыг шийдвэрээр зөвлөмж болгов.

2. Монголын ОУИТБС-ын 2015 оны тайлан, 2016 оны Баталгаажуулалтын дүнгийн талаар ОУ-ын Удирдах хорооноос ирүүлсэн шийдвэрийн танилцуулга- Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон танилцуулав:

а. Шийдвэр: Оролцогч тал бүрээс тус бүр 3 гишүүн орсон Ажлын дэд хэсгийг байгуулахаар тогтов.

б. Оролцогч тал бүр дэд хэсэгт орох өөрийн төлөөллийн нэрсээ 3 дугаар сарын 6-ны дотор Ажлын албанд ирүүлнэ.

і. Дэд хэсгийн хийх ажлын үндсэн үүрэг:

- Монголын ОУИТБС-ын 2016 оны баталгаажуулалт дүнгийн талаар Олон улсын Удирдах хороо болон 2015 оны нэгтгэл тайлангуудаас өгсөн зөвлөмжүүдийг судалж, шийдвэр гаргахад санал боловсруулах, гарсан шийдвэрийн гүйцэтгэлд хяналт тавина.
- Энэ 2 баримт бичгийн хүрээнд гаргасан зөвлөмжүүдийг 2017 оны ажлын төлөвлөгөө болон Хараат бус хянагч нэгтгэгчийн ажлын даалгаварт орсон эсэхийг нягталж, холбогдох засварыг оруулах санал гаргаж Ажлын хэсэгт танилцуулна.
- Өмнөх 2012, 2013, 2014 оны ОУИТБС-ын нэгтгэл тайлангуудаар өгөгдсөн зөвлөмжүүдийн хэрэгжилтийг дахин нягталж, дүгнэлт хийх, шийдвэрийн саналыг Ажлын хэсэгт танилцуулна.

Танилцсан:

Ерөнхий сайдын ахлах зөвлөх,
ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн нарийн
бичгийн дарга, Ажлын хэсгийн ахлагч



Н.Энхбаяр

Хурал даргалсан:

Байгаль орчин ногоон хөгжлийн яамны хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн
газрын ахлах мэргэжилтэн



Б.Саран

Бэлтгэсэн

Ажлын албаны зохицуулагч



Ш.Цолмон